

## ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН БАТЛАН ХАМГААЛАХ ЯАМНЫ ДЭРГЭДЭХ САЛБАР ЗӨВЛӨЛИЙН 2021 ОНЫ 5 ДУГААР ХУРАЛДААНЫ ТОЙМ

Төрийн албаны зөвлөлийн батлан хамгаалах яамны дэргэдэх салбар зөвлөлийн 2021 оны 05 дугаар сарын 19-ний өдөр 05 дугаар хуралдааныг Батлан хамгаалахын сайдын хуралдааны танхимд зохион байгуулж, 3 асуудал хэлэлцэн шийдвэрлэв.

1. Хурандаа цолыг - 4, дэслэгч цолыг - 2 нийт 6 албан тушаалын зэрэглэлийн цэргийн цол олгуулах санал Зэвсэгт хүчний Жанжин штабт хүргүүлхээр хэлэлцэн батлав.

- Мөн хуралдаанаар Дэд хурандаа - 1, хошууч цолыг - 2, ахмад цолыг - 2, ахлах дэслэгч цолыг - 2, дэд ахлагч цолыг - 1 нийт 8 албан тушаалын зэрэглэлийн цэргийн цол тус тус олгохоор хэлэлцэн батлав.

- Мөн хуралдаанаар Зэвсэгт хүчний Жанжин штабын Бодлого, стратегийн төлөвлөлтийн газрын дарга Чимэдгочоо овогтой бригадын генерал Цогтжаргалыг Очирсүх овогтой Дөлгөөнийг Зэвсэгт хүчний Жанжин штабын орлогч даргын албан тушаалд томилуулах дүгнэлт гаргах асуудлыг хэлэлцэн баталж, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тамгын газарт өргөн мэдүүлсэн.

## ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН БАТЛАН ХАМГААЛАХ ЯАМНЫ ДЭРГЭДЭХ САЛБАР ЗӨВЛӨЛИЙН 2021 ОНЫ 6 ДУГААР ХУРАЛДААНЫ ТОЙМ

Төрийн албаны зөвлөлийн батлан хамгаалах яамны дэргэдэх салбар зөвлөлийн 2021 оны 06 дугаар сарын 10-ны өдөр 06 дугаар хуралдааныг Батлан хамгаалахын сайдын хуралдааны танхимд зохион байгуулж, 4 асуудал хэлэлцэн шийдвэрлэв.

1. Хурандаа цолыг - 4, дэслэгч цолыг - 11 нийт 12 албан тушаалын зэрэглэлийн цэргийн цол олгуулах санал Зэвсэгт хүчний Жанжин штабт хүргүүлхээр хэлэлцэн батлав.

- Мөн хуралдаанаар Дэд хурандаа - 1, хошууч цолыг - 10, ахмад цолыг - 2, ахлах дэслэгч цолыг - 3, ахлах ахлагч - 1, дэд ахлагч цолыг - 7 нийт 24 албан тушаалын зэрэглэлийн цэргийн цол тус тус олгохоор хэлэлцэн батлав.

- Мөн хуралдаанаар 1 дэд ахлагч цол, цэргийн албыг сэргээх тухай хэлэлцэн батлав.

- Тулгар төрийн 2230 жил, Их Монгол Улс байгуулагдсаны 815 жил, Үндэсний эрх чөлөө, тусгаар тогтнолоо сэргээн мандуулсны 110 жил, Ардын хувьсгалын 100 жил, Монгол Улсад орчин цагийн Зэвсэгт хүчин үүсэж хөгжсөний 100 жилийн ой-Монгол цэргийн өдрийг тохиолдуулан Батлан хамгаалах яам, Зэвсэгт хүчний Жанжин штаб, харьяа анги, байгууллагуудаас шагнуулахаар тодорхойлолтоо ирүүлсэн Батлан хамгаалах яам, Зэвсэгт хүчний Жанжин штаб, харьяа анги, байгууллагын албан хаагч, ахмад настнуудад дараах шагналыг олгохоор тодорхойлов.

- Монгол Улсын Ардын жүжигчин;
- Монгол Улсын Ардын багш;

- Монгол Улсын Хүний гавьяат эмч;
- Монгол Улсын Эрүүлийг хамгаалахы гавьяат зүтгэлтэн;
- Монгол Улсын Гавьяат жүжигчин;
- Монгол Улсын Шинжлэх ухааны гавьяат зүтгэлтэн;
- Монгол Улсын Гавьяат багш;
- Монгол Улсын Аж үйлдвэрийн гавьяат ажилтан;
- Монгол Улсын Урлагийн гавьяат зүтгэлтэн;
- Сүхбаатарын одон;
- Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одон;
- Алтан гадас одон;
- Цэргийн гавьяаны улаан тугийн одон;
- Цэргийн гавьяаны одон;
- Хөдөлмөрийн хүндэт медаль;
- Цэргийн хүндэт медаль;
- Батлан хамгаалах яамны хүндэт тэмдэг;
- Батлан хамгаалахын тэргүүний ажилтан;
- Батлан хамгаалах яамны Жуух бичиг;
- Дайчин алдар I медаль;
- Дайчин алдар II медаль;
- Дайчин алдар III медаль;
- Ахмад дайчин медаль;
- Эх орны төлөө I хүндэт тэмдэг;
- Эх орны төлөө II хүндэт тэмдэг;
- Эх орны төлөө III хүндэт тэмдгээр нийт 1413 офицер, ахлагч, ажилтан албан хаагч, ахмад настны нэр санлыг тус тус шагнуулахаар дүгнэлт гарган батлав.